beta 0.3

Брэнд хэрэглэгчдэд зориулсан гарын авлага

# БРЭНДЭД ЗОРИУЛСАН ПЛАТФОРМЫН ГАРЫН АВЛАГА

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

# Онцлох боломжууд

Beta 0.3 хувилбарт нэмэгдсэн Брэнд хэрэглэгчдэд зориулсан гол функцууд

### Бүтээгдэхүүнээ нэм

Биет, дижитал, бэлгийн карт, үйлчилгээний эрх — 4 төрлийн бүтээгдэхүүнийг нэг дороос байршуулах боломжтой.

### Хамтрах хүсэлтээ үүсгэ

Хүссэн бүтээгдэхүүн дээрээ хамтрах хүсэлт үүсгэн контент бүтээгчдэд илгээж хамтран ажиллана.

### Хамтралаа BOOST хий

- 3 хоногт яаралтай контент авах
- Зөвхөн PRO бүтээгчтэй хамтрах
- Хүссэн бүтээгчээ сонгох

### Туршлага цуглуул

Имэйл урилга илгээж, өөрийн бодит хэрэглэгчдээс туршлагыг нь контент болгон цуглуулж урамшуулна.

### Контент сан үүсгэ

Хүлээн авсан контентууд хадгалагдан, маркетингийн ажилд дахин ашиглах боломжтой контент сан болж хувирна.

Тун удахгүй

### Geni AI

Цуглуулсан хэрэглэгчдийн туршлага дээрээ хиймэл оюун ухаан ашиглан анализ хийж шийдвэрт ашиглах боломжтой болно.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

**БҮЛЭГ 2.1**

# Шинээр бүртгүүлэх

Брэнд хэрэглэгч болохын тулд эхлээд өөрийн бүртгэлээ үүсгэнэ.

1. **geni.mn** вэб хуудсаар орж баруун дээд буланд байх "**Sign up**" товчин дээр дарна.
2. Имэйл хаяг болон нууц үгээ оруулан шинэ бүртгэл үүсгэх ЭСВЭЛ Google хаягаараа шууд бүртгүүлнэ.

> **Зөвлөмж:** Бусад дэлгэрэнгүй мэдээллүүдийг дараагийн шатанд тусад нь бүрдүүлэх боломжтой тул Алхам 2-г алгасаж болно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 2.2

# Имэйл хаягаа баталгаажуулах

Аюулгүй байдлын үүднээс таны имэйл хаягийг баталгаажуулна.

1. Системээс таны оруулсан имэйл хаяг руу 6 оронтой OTP код илгээгдэнэ.
2. Имэйлээ нээж OTP кодыг хуулна (эсвэл дугаарласаар оруулна).
3. Geni-ийн OTP цонхонд кодоо оруулж "**Үргэлжлүүлэх**" товчийг дарна.
4. Код буруу эсвэл хугацаа нь дууссан тохиолдолд "**Дахин код илгээх**" товчийг дарж шинэ код авна.

> **Анхаар:** OTP код нь 10 минутын дотор хүчинтэй. Спам хавтсаа шалгахаа бүү мартаарай.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 2.3

# Брэнд профайл үүсгэх

Хэрэглэгч бүртгэлээ үүсгэсний дараа Брэнд профайлаа бүрдүүлнэ.

1. Брэндийн логог байршуулна (заавал, 800×800 pxl).
2. Брэндийн нэр болон тухай мэдээллээ оруулна.
3. Регистрийн дугаар оруулна.
4. Үйл ажиллагааны чиглэл болон холбоо барих утасны дугаар оруулна.
5. Сошиал хаяг, вэбсайт, ковер зураг (заавал биш) нэмж болно.

**Зөвлөмж:** Бусад дэлгэрэнгүй мэдээллүүдийг дараагийн шатанд тусад нь бүрдүүлэх боломжтой тул Алхам 2-г алгасаж болно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 2.4

# Үйлчилгээний нөхцөл ба тавтай морил

Профайл бүрдсэний дараа платформ ашиглах эцсийн алхам.

1. Geni платформын үйлчилгээний нөхцөл, нууцлалын бодлоготой танилцана.
2. "**Зөвшөөрч байна**" сонголтын талбарыг идэвхжүүлнэ.
3. Бүртгэл амжилттай дууссан **Welcome** дэлгэц харагдана.

**Дижитал гэрээ:** Бүртгэлийн дараа таны имэйл рүү системийн гэрээний хуулбар очно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 2.5

# Нэвтрэх

Бүртгэлээ үүсгэсэн бол geni.mn-руу хэдийд ч буцан нэвтэрч ажлаа үргэлжлүүлнэ.

1. geni.mn-р орж баруун дээд "**Log in**" товчийг дарна.
2. Бүртгэлтэй имэйл хаяг + нууц үгээ оруулна.
3. Эсвэл "**Google-р нэвтрэх**" товчийг ашиглана.
4. Нууц үгээ мартсан бол "Нууц үг сэргээх" холбоос дээр даран имэйлээ оруулж шинээр үүсгэнэ.




> **Аюулгүй байдал:** Нэвтрэх бүрд OTP код шаардахгүй боловч санамсаргүй нэвтрэлт илрүүлбэл нэмэлт баталгаажуулалт хүснэ.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 3.1

# Үндсэн цэс ба навигаци

Зүүн талын үндсэн цэсээр дамжуулан бүх функц руу шилжинэ.

- Нүүр — Ерөнхий тойм
- Хамтрал — Идэвхтэй болон дууссан хамтралууд + нэмэх
- Туршлага — Хэрэглэгчдийн туршлага + цуглуулах
- Бүтээгдэхүүн — Бүтээгдэхүүний жагсаалт + нэмэх
- Контент — Хүлээн авсан контент сан
- Хянах самбар — Хянах дата мэдээлэл
- Төлбөр — Багц идэвхжүүлэх, сунгах, зогсоох, Данс цэнэглэлт

**Хурдан хайх:** Дээд талын хайлтын мөрөөр хүссэн контент, бүтээгдэхүүнийг шууд олно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 3.2

# Хянах самбарын тойм

Таныг угтаж буй ерөнхий хянах самбар.

1. Хамтралуудын процесс үе шат хянах хэсэг
2. Нээлттэй хуудасны хандалт болон контентуудын engagement дата
3. Сар сараар нь шүүн харах боломжтой
4. Тайлан болгон татаж авах боломжтой

**Шинэ:** Хянах самбар (Dashboard) — багцын хэрэглээ, хандалт, үр дүнгийн дата нэг дороос харагдана.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 4.1

# Багц идэвхжүүлэх

Та зүүн багана болон Төлбөр хэсгээс багцаа идэвхжүүлэх боломжтой.
Багцын төрлүүд

- Starter — 250,000₮: 10 хамтрал, 30 туршлага цуглуулах, 10% буцаалт
- Business — 550,000₮: 20 хамтрал, 100 туршлага цуглуулах, 10% буцаалт
- Corporate — 750,000₮: Хязгааргүй хамтрал, хязгааргүй туршлага цуглуулах, 10% буцаалт




**Бүгд:** Хэтэвч буцаалт 10% + Хянах самбар + Нэмэлт боломжууд хамт ирнэ.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 4.2

# Багцын хугацаа сонгох

Урт хугацаагаар сонгох тусам хямдрал ихсэнэ.

- 1 сар: Багцын стандарт үнэ
- 3 сар: 5% хямдралтай
- 12 сар: 10% хямдрал + Media kit бэлэг (Нийтлэл + Баннер)

Багц сонгосны дараа "**Багц сонгох**" товчоор төлбөр төлөх хэсэг рүү шилжинэ.




**Анхаар:** Дээрх дүнд НӨАТ ороогүй. Эцсийн нэхэмжлэхэд НӨАТ нэмэгдэн тооцогдоно.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 4.3

# Төлбөрийн нөхцөл

5 төрлийн төлбөрийн хэлбэрээс сонгож төлнө.

- Qpay — Бүх банкны апп-р төлөх
- Storepay — Хуваан төлөх
- Bonum-card — Сар бүр автомат сунгалт
- Нэхэмжлэх — Байгууллагын дансаар
- Geni Хэтэвч — Цэнэглэсэн дансаар

**E-barimt:** Төлбөр амжилттай төлөгдсөний дараа баримт автоматаар имэйл рүү ирнэ.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 4.4

# Багцын түүх ба удирдлага

Идэвхтэй багцын төлвийг хянаж, шаардлагатай үед өөрчилнө.

- Хэрэглээний түүх — Хэдэн хамтрал ашигласан, хэд үлдсэн
- Багц ахиулах — Хугацаа дуусахаас өмнө дээд багц руу шилжих (зөрүү төлбөр төлөх)
- Багц буурулах — Зөвхөн хугацаа дууссаны дараа боломжтой
- Багц цуцлах — Шалтгаан илгээж буцаалт хийх хүсэх илгээнэ

**Бэлэг:** Багц ахиулах үед хугацаанд 5 хоног нэмж олгоно.



БҮЛЭГ 5.1

# 4 төрлийн бүтээгдэхүүн байршуулах

Та 4 төрлийн бүтээгдэхүүний төрлөөс сонгож байршуулна.

- Биет бүтээгдэхүүн — Хүргэлтээр илгээх бүтээгдэхүүн
- Дижитал бүтээгдэхүүн — Аппликэйшин, платформ
- Бэлгийн карт — Кодоор идэвхжүүлэх эрхийн бичиг
- Үйлчилгээний эрх — Биет газар очиж идэвхжүүлэх үйлчилгээ

**"Шинэ бүтээгдэхүүн нэмэх"** товчоор шинэ бүтээгдэхүүн оруулах хэлбэр нээгдэнэ.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

**БҮЛЭГ 5.2**

# Биет бүтээгдэхүүн нэмэх

Хэрэглэгчид хүргэлтээр очих биет бараа байршуулна.

1. Бүтээгдэхүүний нэр, төрөл, ангилал, үнэ, тайлбарыг бөглөнө.
2. Бүтээгдэхүүний зураг (нэг ба түүнээс олон) байршуулна.
3. Найрлага, хэрэглэх заавар, хадгалах хугацаа гэх мэт нэмэлт мэдээлэл.
4. Хэмжээ, өнгө, нэмэлт хувилбар нэмнэ.
5. Гадаад холбоос (онлайн дэлгүүр г.м) холбож болно.




**Хүргэлт:** Papa Logistics API-р автомат хүргэлт дуудна.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

beta 0.3

БҮЛЭГ 5.3

# Дижитал бүтээгдэхүүн нэмэх

Онлайн орчинд хүргэгдэх дижитал бараа.

1. Бүтээгдэхүүний нэр, төрөл, ангилал, үнэ, тайлбарыг бөглөнө.
2. Төлбөртэй эсэхийг сонгож үнийг тогтооно.
3. Бүртгэлтэй хэрэглэгчээс ямар мэдээлэл авах вэ — имэйл, утасны дугаар.
4. Дижитал бүтээгдэхүүн рүү очих холбоосыг нэмнэ.




**Жишээ:** Цахим эрх, онлайн курс, гишүүнчлэл, программ хангамж.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 5.4

# Бэлгийн карт нэмэх

QR код байршсан салбар дээр идэвхжих эрхийн бичиг.

1. Эрхийн бичгийн нэр, тайлбар, зургийг оруулна.
2. Үнэ болон ашиглах хугацаа тогтооно.
3. Үйлчилгээ авах салбаруудын нэр, хаягийг оруулна.
4. Систем автоматаар хамтрах хэрэглэгчид ашиглах код үүсгэнэ.

**Идэвхжүүлэх:** Хэрэглэгч салбарт очиж худалдааны зөвлөхөд хэлж QR код уншуулан эрхээ идэвхжүүлнэ.



БҮЛЭГ 5.5

# Үйлчилгээний эрх нэмэх

Биеэр очиж авах үйлчилгээ (массаж, кафе, ресторан г.м).

1. Үйлчилгээний нэр, тайлбар, ангилал, зургийг оруулна.
2. Үнэ ба ашиглах хугацаа тогтооно.
3. Үйлчилгээ авах хаягийн жагсаалт оруулж сонгоно.
4. Систем автоматаар хамтрах хэрэглэгчид идэвхжүүлэх код үүсгэнэ.

**Жишээ:** Хэрэглэгч салбарт очиж касс дээр хэлж QR код уншуулан эрхээ идэвхжүүлнэ.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 5.6

# Бүтээгдэхүүний жагсаалт ба удирдлага

Оруулсан бүтээгдэхүүнүүдээ нэг хуудаснаас хянана.

- Засах — мэдээлэл, үнэ өөрчлөх
- Идэвхгүй болгох — түр зогсоох, дахин асаах
- Бүтээгдэхүүн нэмэх — шинэ бүтээгдэхүүн нэмэх
- Ноорог — бүтээгдэхүүний мэдээллийг хадгалах




**Хайлт:** Бүтээгдэхүүний нэр, төрлөөр шүүж олох боломжтой.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 6.1

# Хамтрах хүсэлт загвар үүсгэх

Хэрэглэгчдэд хамтрах саналаа илгээх анхны алхам.

1. Хамтралын жагсаалтаас "Хүсэлтийн загвар" товчийг дарна.
2. Шинээр загвар үүсгэх болон өмнөх загвараа өөрчилж хадгалж болно
3. Контентоос хүлээж буй хүсэлтийн мэдээллүүдээ оруулна.
4. Контентийн хугацаа болон дүрсний шаардлага дээрх хүсэлтүүдээ оруулна
5. Хэрэглэгчээс хүсэх хүсэлтийн дэлгэрэнгүй болон жишээ контент линк оруулж болно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

**БҮЛЭГ 6.2**

# Хамтрал үүсгэх ба хадгалах

Илгээх бүтээгдэхүүнээ сонгох, тоо ширхэг тогтооно.

1. Хэдэн хэрэглэгчидтэй хамтрах вэ гэдэг тоог тогтооно.
2. Хэрэглэгчид илгээх бүтээгдэхүүнийг сонгоно.
3. Илгээх тоо ширхэгийг оруулна (хамгийн багадаа ₮60,000-н үнэтэй байна).
4. Загварыг шууд илгээх эсвэл "Загвар хадгалах" товчоор хадгалж болно.
5. Хамтрах хүсэлтээ оруулна. Өмнө хадгалсан загваруудаас сонгож болно.

**Багц зарцуулах:** Хамтрах нэг бүр идэвхтэй багцаас 1 эрх зарцуулна.



БҮЛЭГ 6.3

# Хамтралаа BOOST хийх

Хамтрал тус бүр дээр 3 төрлийн нэмэлт боломжоор хамтралаа илүү үр дүнтэй болгох боломжтой.

- Яаралтай — 50,000₮: 3 хоногийн дотор контент авна
- Зөвхөн PRO — 100,000₮: Зөвхөн PRO хэрэглэгчидтэй хамтрана
- Бүтээгч сонгох — 150,000₮+: Хамтрах хэрэглэгчээ сонгоно

BOOST хийгээгүй хүсэлтэд зөвхөн энгийн бүтээгчид хүсэлт илгээж болно.

> **Нэмэлт төлбөр:** BOOST үнэ дээр НӨАТ нэмэгдэж тооцогдоно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 6.4

# Boost хийж хэрэглэгчээ сонгож хамтрах

"Бүтээгч сонгох" BOOST-той үед боломжтой бүтээгчдийн жагсаалтаас сонгоно.

1. Системээс санал болгох бүтээгчдийн жагсаалт харагдана.
2. Бүтээгчийн нэр, профайл зураг, түвшин (Verified / PRO) ил харагдана.
3. Бүтээгчийн өмнөх контентууд, хамтарсан брэндүүдийг үзнэ.
4. Тохирох бүтээгчээ сонгож "Хамтрах" товчийг дарна.

**PRO бүтээгч:** Сүүлийн 10 хамтралын дундаж 4.5+ оноотой бүтээгч.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 7.1

# Хамтралын төлвүүдийн ерөнхий тойм

Бүтээгдэхүүний төрлөөс шалтгаалан хамтрал өөр өөр алхамтай явагдана.

- Хүсэлт баталгаажсан — Хамтрах хүсэлт системд бүртгэгдсэн
- Бүтээгдэхүүн хүлээгдэж байна — Хүргэлт явагдаж буй үе
- Контент хийгдэж байна — Бүтээгчид хугацаа явж буй
- Контент илгээгдсэн — Хянан зөвшөөрөх алхам
- Контент хүлээн авсан — Дууссан хамтрал

**Анхаар:** Контент хоцрогдох тохиолдолд автомат торгууль тооцох систем ажиллана.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 7.2

# Биет бүтээгдэхүүний хамтрал

Хүргэлтээр явдаг бүтээгдэхүүний хамтралын урсгал.

1. Бүтээгчийн хүсэлт ирсний дараа бүтээгдэхүүнийг хүргэх төрлөө сонгоно.
2. Системээр Papa Logistics хүргэлт дуудна.
3. Хүргэлт эхлэх кодоор бүтээгдэхүүнийг хүлээн авна.
4. Бүтээгч хүргэгдсэн дуусгах кодоор баталгаажуулна.
5. Бүтээгдэхүүн хүлээж авмагц 7 хоногийн контент бүтээх хугацаа эхэлнэ.

**Яаралтай:** BOOST ашигласан хүсэлтэд хугацаа 3 хоног болж богиносдог.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 7.3

# Дижитал бүтээгдэхүүний хамтрал

Онлайн орчинд хүрдэг бүтээгдэхүүний хамтралын урсгал.

1. Бүтээгч хүсэлт илгээхдээ имэйл, утасны дугаар зэрэг шаардлагатай мэдээлэл оруулна.
2. Брэнд тал тус мэдээллийн дагуу дижитал бүтээгдэхүүнийг идэвхжүүлнэ.
3. "Идэвхжсэн" төлөвт оруулсаны дараа бүтээгчид мэдэгдэл очно.
4. Идэвхжсэн өдрөөс эхлэн 7 хоногийн контент бүтээх хугацаа явж эхэлнэ.

**Жишээ:** Цахим ном татах эрх, гишүүнчлэлийн нэвтрэх кред.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 7.4

# Бэлгийн карт ба үйлчилгээний эрх

QR код байршсан салбар дээр идэвхжих процесс.

1. Системээс бүтээгчид идэвхжүүлэх ашиглах код илгээгдэнэ.
2. Бүтээгч биеэр салбар дээр очно.
3. Худалдагч салбарын QR кодыг скан хийн ашиглах кодыг оруулна.
4. Худалдагч идэвхжүүлж буй хүний нэр, албан тушаал, утасны дугаарыг оруулна.
5. Брэнд-д "Бүтээгдэхүүн ашиглагдсан" мэдэгдэл очно.

**Олон салбар:** Брэнд олон салбартай үед бүх салбар дээр QR код байршуулсан байх ёстой.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 7.5

# Бүтээгдэхүүн буцаах процесс

Хэрэглэгчээс буцаах хүсэлт ирсэн тохиолдолд авах арга хэмжээ.

- Хэмжээ зөрсөн — буруу хэмжээ илгээгдсэн
- Буруу бүтээгдэхүүн — өөр бараа явсан
- Хугацаа дууссан — хадгалах хугацаа дууссан
- Эвдэрсэн — гэмтэл, хохирол
- Бусад — бусад үндэслэлтэй шалтгаан

Брэнд тал шалган дахин илгээж эсвэл хамтралыг цуцалж болно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 7.6

# Хамтрал цуцлах

Хэрэглэгч 2 шалтгаанаар хамтралыг зогсоож болно.

- Бүтээгдэхүүн таалагдаагүй — Хэрэглэгч сэтгэгдэл бичиж буцаана. Брэнд-д хамтрах эрх буцаалтаар орно.
- Контент бүтээх боломжгүй — Хэрэглэгч шалтгаанаа бичнэ. Бүтээгдэхүүний үнийн дүнг хэрэглэгчээс нэхэмжилнэ.

Хамтрал цуцлагдсан тохиолдолд багцын кредит автоматаар буцаалтаар орно.

**Спам хамгаалалт:** Хэрэглэгчийн дараалсан буцаалт олон болоход систем хязгаарлалт оруулна.



БҮЛЭГ 8.1

# Контент илгээгдсэн — Үзэх

Бүтээгч контентоо илгээсэн дараа Брэнд тал хянана.

1. "Контент илгээгдсэн" төлөвт орсон хамтрал дээр дарна.
2. "Контент үзэх" товчийг дарж Reel/Пост-ыг үзнэ.
3. "Thumbnail" товчийг дарж cover зураг үзнэ.
4. Видео контент бол дуутай үзнэ.



БҮЛЭГ 8.2

# Засвар хүсэлт илгээх

Контент шаардлагад нийцэхгүй бол хамгийн ихдээ 3 удаа засвар хүсэж болно.

1. "Контент засах хүсэлт илгээх" товчийг дарна.
2. Тодорхой засвар оруулах зүйлээ бичнэ.
3. "+" товчоор нэмэлт засвар оруулна (хамгийн ихдээ 3).
4. "Засвар илгээх" товчоор хэрэглэгчид хүсэлт илгээгдэнэ.




**Хариу хугацаа:** Бүтээгч засварыг 48 цагийн дотор хийж дахин илгээнэ.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

**БҮЛЭГ 8.3**

# Контент хүлээн авах + оноо

Контент таалагдвал хүлээн авч оноо өгнө.

1. "Контент хүлээж авах" товчийг дарна.
2. Контентийн хийцлэлд 0-5 одны оноо өгнө.
3. Контентийн агуулгад 0-5 одны оноо өгнө.
4. Бүтээгчид сэтгэгдэл үлдээнэ (заавал биш).
5. Пост хийх хүсэлтийг сонгоно (бүтээгчийн суваг / коллаб / зөвхөн Брэнд).

> **1-с бага оноо:** Систем засвар илгээхийг санал болгоно. Боломжгүй бол шалтгаан бичиж буцаана.



БҮЛЭГ 8.4

# Онцгой тохиолдол — хоцорсон/блоклогдсон

Бүтээгч хугацаандаа контент илгээгээгүй үед.

- 3-5 хоног хоцорсон — Системээс анхааруулга,
- 7-10 хоног — Хэрэглэгчид торгууль тооц + хоцрогдолын түүх
- 10 хоногоос дээш — Блоклогдсон — Бүтээгдэхүүний үнийн дүнг бүтээгчээс нэхэмжилнэ. Брэнд-д хамтрах эрх буцаалтаар орно.

**Автомат:** Бүх төлбөр, торгууль, эрх буцаалт автоматаар тооцогдоно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 9.1

# Хэрэглэгчдээ имэйл урилга илгээх

Бодит хэрэглэгчдээсээ туршлага хүсэх анхны алхам.

1. "Туршлага цуглуулах" хэсэгт орж "Имэйл урилга" товчийг дарна.
2. Имэйлийн дизайныг загвараас сонгоно эсвэл өөрөө загвар үүсгэнэ.
3. Урих хэрэглэгчдийн имэйл хаягуудыг оруулна.
4. Тестээр өөртөө илгээж урьдчилан үзнэ.
5. "Илгээх" товчоор бүх хэрэглэгчдэд илгээнэ.

**Жишээ:** Захиалагч, лояалти гишүүд, өмнөх хэрэглэгчдийн жагсаалт.



БҮЛЭГ 9.2

# Хэрэглэгчээс ирсэн туршлагыг хянах

Урилгад хариу өгсөн хэрэглэгчдийн туршлагуудыг харах хэсэг.

1. "Туршлага" хэсэгт орж ирсэн туршлагуудын жагсаалтыг харна.
2. Туршлага бүр дээр бүтээгдэхүүн, хэрэглэгч, текст, зураг/видео харагдана.
3. "Дэлгэрэнгүй" товчоор туршлагын бүх агуулгыг харна.
4. Шүүлтүүрээр огноо, оноо, бүтээгдэхүүнээр шүүж болно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 9.3

# Туршлага хүлээн авч урамшуулал өгөх

Туршлагыг хүлээн авч Geni Point-оор урамшуулна, эсвэл буцаана.

- Пост туршлага: 1,000 / 3,000 / 10,000 / 30,000 GP
- Reel туршлага: 5,000 / 10,000 / 30,000 / 50,000 GP
- Сэтгэгдэл: Хэрэглэгчид нэмэлт талархлаа илэрхийлнэ

Хүсэлт нийцэхгүй бол шалтгаан бичиж буцаана. Урамшуулал нь Брэндийн хэтэвчнээс автоматаар хасагдана.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

**БҮЛЭГ 10.1**

# Төлбөр ба хэтэвч

Төлбөр хэсэгт байрших Geni-ийн дижитал хэтэвч систем — мөнгөний урсгалаа платформ дээрээ удирдана.

- Дансны баланс — Одоо байгаа мөнгөн дүн
- Идэвхтэй багцын мэдээлэл — Багцын мэдээлэл
- Дансны түүх — Хэрэглэгчдэд урамшуулал, Cashback
- Тооцооны түүх — Бүх гүйлгээний жагсаалт




**Буцаалт:** Багц авсан үнийн дүнгийн 10% автоматаар хэтэвчинд буцаалтаар орно.

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 10.2

# Хэтэвч цэнэглэх

Хэрэглэгчдэд урамшуулал өгөх, нэмэлт төлбөр төлөхөд бэлэн мөнгө цэнэглэнэ.

1. "Хэтэвч — Цэнэглэх" товчийг дарна.
2. Цэнэглэх дүнгээ оруулна (₮50,000-аас эхлэн).
3. Төлбөрийн нөхцөл сонгоно: Qpay / Карт / Нэхэмжлэх.
4. Төлбөр амжилттай төлөгдсөний дараа баланс шинэчлэгдэнэ.

**E-barimt:** Цэнэглэлтийн баримт автоматаар имэйл рүү очно.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 11.1

# Профайл тохиргоо

Хувийн ба Брэндийн мэдээллээ удирдана.

- Хувийн мэдээлэл — Овог, нэр, утас, имэйл солих (OTP-аар)
- Брэнд мэдээлэл — Лого, нэр, тухай, регистр, ҮА чиглэл
- Хаягууд — Олон салбарын хаяг хадгалах
- Сошиал, вэбсайт — Олон нийтийн хаяг холбох
- Гэрээ — E-geree систем дээрх гэрээний хуулбар
- Нууцлал — Нууц үг солих, аюулгүй байдал




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

**БҮЛЭГ 11.2**

# Контент сан

Хүлээн авсан бүх контент 3 категорид хадгалагдана.

- Хүлээн авсан контент — Брэндийн сан дотор
- Хамтарсан контент — Бүтээгчтэй коллаб болсон
- Нийтлэсэн контент — Брэндийн нээлттэй хуудсанд байршсан

Контент бүрийн дэлгэрэнгүй харах, татаж авах, нээлттэй хуудсанд нийтлэх боломжтой.

**Маркетинг:** Цуглуулсан контентыг өөрийн сошиал суваг, веб сайт, рекламанд ашиглаарай.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

БҮЛЭГ 11.3

# Нээлттэй Брэнд хуудас

Таны брэндийг олон нийтэд танилцуулах нээлттэй хуудас.

- Брэнд мэдээлэл — Лого, ковер зураг, тухай, сошиал хаяг
- Брэнд experience — Брэндийн нийтлэсэн контентууд
- Бүтээгдэхүүнүүд — Идэвхтэй бүтээгдэхүүний жагсаалт
- Хэрэгтэй/Хэрэггүй reaction — Бүртгэлтэй хэрэглэгчийн санал
- Сошиал хуваалцах — Шууд Facebook/Instagram руу хуваалцах

> **Dashboard:** Нээлттэй хуудас дээрх хандалтын дата мэдээлэл “Хянах самбар” хэсэг дээр харагдана.




© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Тусламж ба санал хүсэлт

# ТАНД ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл бид онлайн уулзалтаар танд илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгөх боломжтой.


Имэйл

**support@geni.mn**

Утас

**+976 8812-3818**

Вэбсайт

**www.geni.mn**


© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

beta 0.3

*Дараа дараагийн шинэчилсэн хувилбараар уулзъя!*

# ҮНЭН ТУСМАА ҮНЭ ЦЭНТЭЙ

© Geni 2026 · Бүх эрх хуулиар хамгаалагдсан.